

# МОНГОЛ-ГЕРМАНЫ ХАРИЛЦААНЫ ГОЛ ҮЙЛ ЯВДЛУУД

(2007 оны эхэн хагаст)

**2007.01.12.**

Ханс Зайделийн сангийн Монгол дахь Төлөөлөгчийн Газар, Эрх зүйн боловсрол Академиас ардчилсан шинэ Үндсэн хууль баталсны 15 жилийн ойг тохиолдуулан 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиудыг эмхэтгэсэн ном хэвлүүлснээ олон нийтэд танилцуулах ажиллагаа болов.

**2007.02.05-06.**

Гэрэл зурагчин хатагтай Зибилле Бергманн Монголын загварын фото зураг сонирхогчдод зориулан "Монгол костюмс" төвд сургалт зохион байгуулав.

**2007.02.13.**

ХБНГУ-ын Мюнхен хотноо Мюнхений аюулгүй байдлын 43 дугаар бага хурал "Глобаль асуудалд-Глобаль хариуцлага" сэдвийн хүрээнд болж, Холбооны Канцлер А. Меркель, ОХУ-ын Ерөнхийлөгч В. В. Путин, АНУ-ын Батлан Хамгаалахын сайд Роберт Гейт, НАТО-гийн Ерөнхий нарийн бичгийн дарга Ясап де Хооп Шеффер зэрэг 350 төлөөлөгч, 180 орчим ажиглагч оролцжээ. Бага хурлын дарга Х. Тельчикийн урилгаар Монгол Улсын Гадаад Хэргийн сайд Н. Энхболд тус оролцож, Австрали, Австрийн Гадаад Хэргийн сайд, ХБНГУ-ын Холбооны Гадаад Харилцааны Яамны Төрийн нарийн бичгийн дарга, Холбооны Батлан Хамгаалах Яам-Парламентын Төрийн нарийн бичгийн дарга болон албаны бусад хүмүүстэй уулзаж ярилцан санал солилцжээ.

**2007.02.16.**

Монгол Улсын Ерөнхий сайд М. Энхболд Фридрих Эбертийн сангийн Ази, Номхон далайн газрын дарга хатагтай Биате Бартольдус, тус сангийн Монголыг хариуцсан захирал Роланд

Файхт нарыг хүлээн авч уулзав. Уулзалтын үеэр ноён Роланд Файхтыг МАХН-ын шагнал болох "Хүндэт тэмдэг"-ээр шагнасныг Ерөнхий сайд, МАХН-ын дарга М. Энхболд гардуулав.

#### **2007.02.24.**

Ханс Зайделийн сангийн Монгол дахь Төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол Академиас эрхлэн сар бүрийн дөрөв дэхь долоо хоногийн баасан гарагт тогтмол явуулдаг захиргаа, хөдөлмөр, иргэний болон эрүүгийн эрх зүйн чиглэлээр мэргэжсэн хуульч, өмгөөлөгчдөөр иргэдэд үнэгүй зөвлөгөө өгөх үйл ажиллагаа явагдав.

#### **2007.02.29.**

"Таван Богд трейд" ХХК Германы "Henkel" компаний албан ёсны дистрибьютер болсноо зарлаж, хэвлэлийн бага хурал хийв. Хэвлэлийн бага хуралд компаний удирдлага "Henkel" фирмийн мэргэжилтнүүд оролцов.

#### **2007.03.07-11.**

Берлин хотноо аялал жуулчлалын чиглэлийн ITB-2007 олон улсын үзэсгэлэн зохион байгуулагдаж, нийт 184 орны 11 мянган байгууллага (160 мянган кв.м талбайд) оролцов. 41 дэхь удаагаа уламжлал болон явагдаж байгаа оролцогчдын тоо, хамрах хүрээгээр дэлхийд тэргүүлдэг уг үзэсгэлэнд манай улс 9 дэхь жилдээ оролцсон бөгөөд "Цолмон трэйвел", "Актив энд Эдвейзер тур", "Мондисвари", "Жуулчин", "Ар Монгол Трэйвел", "МИАТ", "Цэрэн турс", "Скайлэнд тур" зэрэг 8 компани нэгдсэн зохион байгуулалттайгаар 104 кв.м талбайд үзэсгэлэнгээ зохион байгууллаа. Үзэсгэлэнгийн үеэр "Дисковер Монголиа" хэвлэлийн бага хурлыг Монгол Улсаас ХБНГУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Л. Галбадрах нээж, ЗТАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга У. Бат-Энх "Монгол Улсын аялал жуулчлалын хөгжил" сэдвээр илтгэл тавив.

#### **2007.03.08.**

Жил бүр сурагчдын дунд зохиогддог герман хэлний олимпиад болж, герман хэлний сургалттай 8 сургуулийн 163 сурагч оролцон

ялагчаа тодруулав. БСШУЯ, ХБНГУ-ын ЭСЯ, Гёте сургуулийн төлөөлөгчид болон герман хэлний зөвлөх багш нар олимпиадад түрүүлсэн сурагчдад шагнал гардуулав.

### **2007.03.14.**

Үндэсний Түүхийн Музейд Монголын Эзэнт Гүрний нийслэл Хархорум хотын 1: 350 масштабтай загварыг хүлээлгэн өгөх ёслол болов. Ёслолын ажиллагаанд ГХЯ-ны Дэд сайд Ц. Цолмон, БСШУЯ-ны Дэд сайд С. Төмөр-Очир, ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ульрих Дрээзэн, БНТУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Өмүр Шөлэндил нарын албаны хүмүүс оролцов. Уг загварыг бүтээхэд Монгол-Германы археологийн хэсгийн ахлагч, профессор Х. Г. Хюттель зөвлөхөөр ажиллаж, загвар бүтээгч Бернд П. Каммермайер хийж гүйцэтгэжээ.

### **2007.03.15.**

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулж, ХБНГУ-ын ZDF олон нийтийн телевиз, найруулагч Кристиан Твейтегийн удирдлагаар Чингис хаан болон түүний залгамжлагч хаадын тухай "Монголчууд" нэртэй 2 ангит түүхэн баримтат киног бүтээсэн бөгөөд уг киноны нээлт "Тэнгис" кино театрт болов. Уг киног "Монгол-Германы гүүр" ТББ-ын хамтын олны хүчин чармайлтаар мөн сарын 17, 18 нд МҮОНТ-ээр олон нийтийн хүртээл болгов.

### **2007.03.16.**

Хумбольдтын Их Сургуулийн Институтээс уламжлал болгон зохиодог "Бүх Европын Кингру-2007" олон улсын математикийн олимпиад олон улсын 550 мянга гаруй сурагчдын дунд тухайн улсад суугаа ХБНГУ-ын Элчин сайдын яамаар дамжуулан онлайн хэлбэрээр зохиогдсоноос манай улсын "Гэгээрэл", "Эхлэл", 1-р сургуулийн 60 гаруй сурагчид оролцож, ангала тус бүрийн 1-р байранд 7, 2-р байранд 5 сурагч тус тус шалгарав.

### **2007.03.17-24.**

Конрад Аденауэрын сангийн санхүүжилтээр Сант Марал сан Өвөрхангай, Увс, Сэлэнгэ, Сүхбаатар аймгийн 1767 иргэдийн дунд

Монголын улс төрийн өнөөгийн байдалд хэрхэн дүгнэлт хийж буй талаар судалгаа явуулав.

### **2007.03.18-25.**

Ханс Зайделийн сангийн урилгаар Монгол Улсын Дээд Шүүхийн Эрүүгийн хэргийн Эрүүгийн танхимын Ерөнхий шүүгч Д. Батсайхан, Захиргааны хэргийн танхимын Ерөнхий шүүгч О. Зандраа нараар ахлуулсан 10 шүүгч ХБНГУ-д ажил хэргийн айлчлал хийв. Айлчлалын хүрээнд энэ онд батлан гаргахаар төлөвлөж буй Монгол Улсын Эрүүгийн хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбарыг боловсруулах чиглэлээр Монгол Улсын Улсын Дээд Шүүх болон Ханс Зайделийн сангаас хамтын ажиллагааны дагуу манай шүүгчид ХБНГУ-д судалгаа хийж, эрдэмтэн судлаачидтай хамтарсан семинаруудыг зохион байгуулав. Мөн Бавари муж улсын Дээд Шүүх, Захиргааны хэргийн шүүх, хуулийн бусад байгууллагад зочилж, холбогдох албаны хүмүүстэй ажил хэргийн уулзалт хийв.

### **2007.03.23-25.**

Оросын соёл, шинжлэх ухааны мэдээллийн төвд Олон улсын боловсролын үзэсгэлэн яармаг болж, ХБНГУ-ын их, дээд сургууль хэлний болон боловсролын солилцооны төвүүдээс төлөөлөгчид оролцов.

### **2007.03.29.**

Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалагч нарын зөвлөлгөөн боллоо. Зөвлөлгөөнд Улсын Мэргэжлийн Хяналтын Газар, Цагдаагийн Ерөнхий Газрын Хэрэг бүртгэх Газар, Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (ГТХАН)-ийн Байгаль хамгаалал, байгалын нөөцийн тогтвортой менежмент хөтөлбөр оролцов.

### **2007.04.20.**

Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын дарга, хурандаа Д. Батжаргал, Дархан-Уул аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга, хурандаа М. Цэнд нарын бүрэлдэхүүнтэй хүмүүс

ХБНГУ-ын Нордрайн-Вестфален муж улсын Хорих байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлаад ирэв.

#### **2007.04.20.**

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн салбарт дэмжлэг үзүүлэх Монгол-Германы хамтарсан төслийн төгсгөлийн үнэлгээ, үр дүнгийн хурал Улаанбаатар хотноо болж, ЭМЯ, ХБНГУ-ын ЭСЯ, Германы Техникийн Хамтын Ажиллагааны нийгэмлэг (ГТХАН), НҮБ-ын Хүн амын сан, "Гал голомт" ТББ, аймаг орон нутгийн төрийн болон эрүүл мэндийн байгууллагуудын төлөөлөл оролцов. Тус хөтөлбөр манай орны 39 сум, нийслэлийн 3 дүүрэгт хэрэгжиж, нийт хүн амын 14 хувь буюу 330 мянган хүн хамрагджээ.

#### **2007.05.14.**

Газрын харилцаа, геодези зураг зүйн газар ХБНГУ-ын Хессен муж улсын Газар зохион байгуулалт, геомэдээллийн газрын хамтын ажиллагааны дагуу Эдийн засаг, Зам тээвэр, Хотын хөгжлийн Яамны зөвлөх Хелге Байерсдорфор, Газар зохион байгуулалт, геомэдээллийн газрын дарга Вульф Шредер нар манай улсад ажлын айлчлал хийв. Төлөөлөгчид айлчлалынхаа хүрээнд Улаанбаатар, Дархан-уул аймгийн Газрын алба болон Газрын харилцаа, геодези зураг зүйн газарт хэрэгжиж буй Германы Техникийн Хамтын Ажиллагааны нийгэмлэг (ГТХАН)-ийн "Санхүүгийн кадастр", Азийн Хөгжлийн Банкны "Кадастрын зураглал ба газрын бүртгэл", СИДН-гийн "Газрын харилцааны салбарыг хөгжүүлэх, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх төсөл"-үүдийн үйл ажиллагаатай танилца

#### **2007.05.18.**

ХБНГУ-ын Заксен муж улсын Лейпциг хотноо албан ёсоор Өргөмжит консулын үйл ажиллагаагаа эхэлж буй ХБНГУ-ын иргэн Вольфганг Вилле-д Элчин сайд Т. Галбаатар Өргөмжит консулын үнэмлэх бичиг, тамга, далбааг нь гардуулав. Энэ үеэр Элчин сайд Т. Галбаатар Өргөмжит консул В. Вилле нар хамтран ажиллах тухай Протоколд гарын үсэг зурав. Албан ёсны энэхүү үйл ажиллагаанд Лейпциг хотын орлогч дарга, тус хотын Урчуудын танхимын дарга

болон Элчин сайдын яамны дипломат ажилтнууд, албаны хүмүүс оролцов.

Германы Археологийн Институт хуралдаанаараа Монгол Улсын ШУА-ийн Археологийн Хүрээлэнгийн захирал, доктор, профессор Д. Цэвээндоржийг тус Институтийн гадаад сурвалжлагч гишүүнээр сонгов.

### **2007.05.23.**

"Уурхайн хаалтын горим, байгаль орчны нөхөн сэргээлтийн менежментийн асуудал" сэдэвт семинарыг Ашигт малтмал, Газрын тосны Хэрэг Эрхлэх Газар, Байгаль Орчны Яам, Улсын Мэргэжлийн Хяналтын Газар, ШУТИС-ийн Уул Уурхайн Сургууль, ХБНГУ-ын StuBA, LMBV байгууллагатай хамтран зохион байгуулав.

### **2007.05.28-29.**

Монгол Улсын Гадаад Хэргийн сайд Н. Энхболд ХБНГУ-ын Хамбург хотноо болсон Ази-Европын уулзалт(АСЕМ)-ын гишүүн орнуудын Гадаад хэргийн сайд нарын VIII уулзалтад оролцов.

### **2007.05.28.**

ХБНГУ-ын Засгийн газрын дэмжлэгтэй Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GTZ)-ийн "Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр", Мерси Кор (Mercury Corps) байгууллагын АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны санхүүжилттэй "Хөдөөгийн агро бизнесийг дэмжих хөтөлбөр"-үүд үйлдвэрлэл ба боловсруулах чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хөдөөгийн бизнесменүүд санхүүгийн байгууллагаас зээл авах боломжийг нь бүрдүүлж, бизнесийн үйл ажиллагаагаа цар хүрээгээ өргөтгөхийн тулд нэмэлт барьцаа хөрөнгө гаргах талаар Завхан аймагт хамтран ажиллах зорилго бүхий саналын бичигт "Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр"-ийн удирдагч фон Франц, "Хөдөөгийн агро бизнесийг дэмжих хөтөлбөр"-ийн захирал Питер Ормел нар гарын үсэг зув.

**2007.05.29-31.**

Хатагтай Хеде Вегенер тэргүүтэй ХБНГУ-ын Бундестагын Аюулгүй байдлын байнгын хорооны гишүүд манай улсад айлчлав.

**2007.06.04-10.**

ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны санхүүжилтээр Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг /GTZ/, Монгол Улсын Газрын харилцаа, геодези, зураг зүйн газартай хамтран хэрэгжүүлж буй "Газрын менежмент ба санхүүгийн кадастр" төслийн хүрээнд ХБНГУ-д танилцах аялалыг УИХ-ын гишүүд, сайд нар, агентлаг, газрын дарга, орон нутгийн газрын албаны удирдлага, мэргэжилтнүүд, энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн багш нарыг хамруулан зохион байгуулав.

**2007.06.05**

Монгол Улсын Ерөнхийлөгч Н. Энхбаяр манай улсад айлчилж буй ХБНГУ-ын Конрад Аденауэрийн сангийн Ерөнхийлөгч Бернхард Фогелийг хүлээн авч уулзав.

**2007.06.07**

Монгол Улсын Сангийн яам, Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэгтэй хамтран "Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-ийг Дархан-уул, Орхон, Завхан зэрэг аймагт 2006 оны 6-р сараас эхлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд 4 жилийн хугацаатай 4 шатлалаар хэрэгжих тус хөтөлбөрийн зохицуулагч ноён ИФонФранц манай улсын арилжааны банкуудтай хамтран ажиллахаар тохиролцож, хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурав.

**2007.06.22.**

Манай Улсын Засгийн газар болон ХБНГУ-ын Засгийн газар хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд манай улсын Сангийн яам, Монгол Банк болон Монголын Ипотекийн Корпораци /МИК/ хамтран ХБНГУ-ын Сэргээн Босголтын Банк "KfW"-тай орон сууцны зээлийн урт хугацааны санхүүжилтийн

эх үүсвэрт зориулан 5,3 сая еврогийн зээлийн эрх авах тухай Харилцан Ойлголцлын Санамж Бичигт гарын үсэг зурлаа.

### **2007.06.23.**

Любик хотноо 06-р сарын 25-нд эхлэх Европын цуврал тэмцээнд оролцох манай өсвөрийн 26 гандболчдоос бүрдсэн баг ХБНГУ-г зорив.

### **2007.06.26**

Ерөнхийлөгч Н. Энхбаяр ХБНГУ-аас манай улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Эрнест Улрих Дрезенийг Элчин сайдын үүрэгт ажлаа өндөрлөх болсонтой холбогдуулан хүлээн авч уулзлаа.

### **2007.06.28**

Монгол Улсын Засгийн газрын урилгаар Германы Эдийн засаг, технологийн сайд ноён Михаэл Глос тэргүүтэй төлөөлөгчид манай оронд айлчилав. Төлөөлөгчид МҮХАТ-ын дугуй зааланд Монгол-Германы бизнесийн уулзалт хийв. Мөн Холбооны сайд М. Глос Монгол Улсын Ерөнхий сайд М. Энхболдод бараалж, дараа нь хэвлэлийнхэнд Төрийн ордны В танхимын гаднах талбайд ярилцлага өгөв. Германы Эдийн засаг, технологийн сайд М. Глос тэргүүтэй тус улсын төрийн болон бизнесийн төлөөлөгчдийн хийж буй айлчлалын үеэр Монгол-Германы эдийн засгийн бизнес уулзалт болж, манай ХХБ, Германы Бавари мужийн "Ландес" банктэй зээлийн хэлэлцээр байгуулах юм. Германы төлөөлөгчид манай АМГТ-ны ХЭГ-ын урилгаар ирж байгаа бөгөөд төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Германы Бундестагийн зарим гишүүд, тус улсын "МЕТРО" групп, "Данко", "Тайссен Крупп технологи" зэрэг томоохон компаниуд болон "ZDF", "Фокус", "Билд", "Майн фост" зэрэг мөн томоохон хэвлэл, мэдээллийн сэтгүүлч сурвалжлагчид ирлээ.

*Эмхэтгэсэн: Р. Төрдалай  
(ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэн)*